

### 3. Байгууллагын санхүү нэгтгэл

Энэхүү модулийн зорилго нь анхан шатны баримт, нягтлан бодох бүртэлийн журналд үндэслэн төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалаар батлагдсан маягтын дагуу орлого, зардал, хөрөнгийн мэдээллийг бүртгэх, удирдах юм. Дээд боловсролын сургалтын байгууллага нь орлого, зарлага, хөрөнгийн мэдээг санхүүгийн жил бүрээр бүртгэн удирдах ба БШУЯ болон яамны харъяа байгууллагууд өөрийн эрхийн хүрээнд мэдээллийг харах, хянах ба мэдээлэлд дүн шинжилгээ хийх, статистик, аналитик тайлан харах, мэдээллийг эксел, pdf файлууд руу татан авах боломжтой.

